

**ОУВС-гийн ажлын хэсэг Шуурхай санхүүжилтийн хэрэгсэлд Монгол Улсыг
яаралтай хамруулах хэлэлцээрт хүрлээ**

Ажлын хэсгийн гаргаж байгаа хэвлэлийн мэдээлэл нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийн баг гишүүн оронд ажиллаж гаргасан урьдчилсан үр дүнг танилцуулдаг. Энэхүү мэдээлэлд илэрхийлсэн байр суурь нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийн байр суурь бөгөөд тус сангийн Захирлуудын зөвлөлийн байр суурийг заавал илэрхийлэхгүй. Үнэлгээний урьдчилсан үр дүнд үндэслэн ажлын хэсэг тайлан боловсруулж, ОУВС-гийн удирдлагаар батлуулсны дараа Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

- КОВИД-19 цар тахлаас үүдэлтэйгээр Монгол Улсын эдийн засагт бий болоод байгаа хүндрэлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх ОУВС-гийн Шуурхай санхүүжилтийн хэрэгсэл (ШСХ)-д яаралтай хамруулах хэлэлцээрт ажлын хэсгийн түвшинд хүрлээ.
- КОВИД-19 нь Монгол Улсын макро эдийн засгийн төлөвийг сулрууллаа. Засгийн газраас вируст халдварын тархалтыг хязгаарлахын тулд шуурхай арга хэмжээг авсны дээр эдийн засгийг сэргээх, нийгмийн нөлөөллийг бууруулах өргөн хэмжээний багц арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.
- ОУВС-гийн Захирлуудын зөвлөлөөр ШСХ-д хамруулах хүсэлтийг баталснаар бусад донор орнуудтай хамтран Монгол Улсын төсөв болон төлбөрийн тэнцлийн яаралтай хэрэгцээг хангахад туслалцаа үзүүлнэ. Уг хүсэлтийг Захирлуудын зөвлөлөөр 6 дугаар сарын эхэнд хэлэлцэх хүлээлттэй байна.

Жэф Готтлийбээр ахлуулсан Олон улсын валютын сан (ОУВС)-ийн ажлын хэсэг 2020 оны 5 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Монгол Улсын эрх баригчидтай цахим уулзалт зохион байгуулж 72.3 сая ТЗЭ (99 сая ам.долларын) санхүүжилт бүхий яаралтай санхүүжилт олгох хүсэлтийг хэлэлцлээ.

Уулзалтын үеэр КОВИД-19 цар тахлын Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй нөлөө, эрүүл мэндийн эрсдэлийг хязгаарлах төлөвлөгөө, өрийн тогтвортой байдал, нөөцийн хүрэлцээ зэрэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүллээ.

Ажлын хэсгийн уулзалтыг дүгнэж ноён Готтлийб дараах мэдэгдлийг хийв:

“КОВИД-19 цар тахлаас үүдсэн эдийн засгийн хямралаас урьдчилан сэргийлэх, эмзэг бүлгийн иргэдийг хамгаалахаар авч хэрэгжүүлж буй бодлогын тухай үр дүнтэй

хэлэлцүүлэг боллоо. Өнөөг хүртэл Монгол Улс вирусийн тархалтыг амжилттай хязгаарлаж байна. Хэдий тийм ч экспортын орлогын бууралт болон цар тахлын эсрэг авч буй арга хэмжээнүүд нь эдийн засагт томоохон сорилт болж байна.

“Монгол Улсад ОУВС-ын дэмжлэгтэй хэрэгжиж буй, 2020 оны 5-р сарын 23-нд эцэслэх хөтөлбөрийн хүрээнд улсын өрийг бууруулах, нөөц хуримтлуулах зэрэг чиглэлээр эдийн засгийн дархлааг бэхжүүлэхэд сүүлийн жилүүдэд томоохон ахиц гарлаа. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд эрсдэлээс хамгаалах бодлогыг бий болгосны үр дүнд эрх баригчдын зүгээс тахлын эсрэг тэмцэх яаралтай арга хэмжээг авах чадамжийг бүрдүүлжээ.

“Анхаарвал зохих нэн тэргүүний зорилт бол тахал өвчин болон түүний нөлөөнд хамгийн их хохирч болзошгүй эмзэг бүлэгт чиглэсэн Засгийн газрын үр ашигтай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явдал юм. Түүнчлэн, цар тахлын макро эдийн засгийн тогтвортой байдалд учруулж буй дарамтыг бууруулахын тулд эрх баригчид зардлаа эрэмбэлэх замаар төсвийн сахилга батыг хангах, илүү уян хатан ханшийн системийг хүлээн зөвшөөрч ч ихээхэн хүчин чармайлт гаргаж хуримтлуулсан нөөцөө хадгалах шаардлагатай юм.

“Харин вирусийн тархалт багассаны дараа дотоодын өрийг бууруулах, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, банкны өөрийн хөрөнгийг өсгөх чиглэлд арга хэмжээ авахыг зөвлөж байна. Ялангуяа, эрх баригчдын зүгээс Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн үргэлжлэл болгон банкны салбарын шинэчлэлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхтэй санал нэгдсэн.

“Ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, бүтээлч яриа хэлэлцээ өрнүүлсэнд эрх баригчдад талархал илэрхийлье.”